



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 1/33

Алтай хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн халаалтын зуух цоорч, хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл үүссэн тул халаалтын тогоо, инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээг хийж, хэвийн горимд оруулахад шаардагдах 14,895,000 (арван дөрвөн сая найман зуун ерэн таван мянга) төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР